

**Монгол хэлний өнгөний нэрээр илрэх утгын
өргөслийг судлах нь**
(Бор өнгөний нэрийн жишээн дээр)

Равжирын Сарангэрэл^{ORCID}

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс.

Хүлээн авсан - Received:

2024-10-24

Засварласан - Revised:

2024-11-27

Хэвлэгдсэн - Published:

2024-12-30

sarangerel.r@msue.edu.mn

ORCID: [0000-0002-6345-9447](https://orcid.org/0000-0002-6345-9447)



© 2024, Author(s)

Хураангуй: Тус өгүүлэлд монгол хэлний “бор” өнгөний нэр бүхий нийлмэл нэгжээр илрэх утга, утгын хувьсал, өргөсөл, утгын хүрээг утга зүй, танин мэдэхүйн үүднээс авч үзлээ. “Бор” өнгөний нэрээс улбаатай утгын өөрчлөлтийг авч үзэхэд “*өнгө заах, ядуу дорой, эгэл энгийн, энхрий дотно, дулаан тайван, харанхуй бүрэнхий*” 6 салаа утгыг үүсгэж байгаа бөгөөд 3156 хэлийг багтаасан утгын хүрээтэй (semantic map) харьцуулж үзэхэд “бор” өнгөний нэрээс үүссэн утгын хүрээ нь бусад хэл соёлт ард түмнээс ялгаатай байна. Мөн түүнчлэн утгын өргөсөл нь бор өнгөний хүний сэтгэл зүйд нөлөөлөх нөлөөлөл болон хүн төрөлхтний орон зайн босоо чигийн төлөөлүүлсэн “хөх-тэнгэр”, “бор-газар” гэх өнгөний бэлгэдэлтэй холбоотой газар хөрсний өнгө, мөн монгол хүний царайны өнгөнөөс улбаатай нийлмэл нэгж үүсэх суурь болж, үгийн сангийн утгаас гадна хэлний соёл хэрэглээ, хэлний үнэлэмж, бэлгэдэлтэй холбогдож, утгалбарын хувилбар буюу салаа утгууд нь нийлмэл нэгжээр илрэхдээ танихуйн зүйрлэлийн шинжтэй, соёл сэтгэлгээний онцлогийг тээж бүтжээ.

Эдгээр нийлмэл нэгжээр илрэх утга нь үгийн сангийн утгаас гадна соёлын үнэт зүйл, үнэлэмж, бэлгэдлийн утгыг багтааж, соёл хэрэглээний талын тодруулан, үгийн утга түүгээр илрэх үнэлэмж, соёлын асуудлыг хөндсөнөөрөө үгийн сангийн утга судлал, үгийн утгын соёл танихуйн асуудал, угсаатны зүйн судалгаанд ч холбоотой. Нөгөө талаас тухайн ард түмний түүх, ёс заншил, амьдралын тогтсон хэв маяг, сэтгэлгээний онцлогийг хэлээр дамжуулан сурдаг тул монгол хэл сурах, заах асуудалд тодорхой хувь нэмэр оруулахаас гадна соёлыг хэлээр дамжуулан таниулах, хамгаалахад чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг: бор, өнгөний нэр, утгын өөрчлөлт, өргөсөл, утгын сүлжээ (хүрээ), зүйрлэл

ОРШИЛ

Дэлхий дээрх олон өнгө хүний хараагаар дамжин ойлголтуудыг бий болгож байдаг. Хүн төрөлхтний гэрэл гэгээ, харанхуй сүүдрийг мэдрэх мэдрэмжтэй холбоотой хар, цагааныг үзэх уламжлал сэтгэлгээ түүний бэлгэдэл, мөн чанар нь тухайн үндэстний соёлын онцлогтой холбогдоно. Өнгөний нэрийн айн судалгааг (Берлин & Кау, 1969) оны бүтээлээрээ 20 хэлний үндсэн өнгөний нэрийн хувьсал, нийтлэг шинжийг харьцуулж, дэс дарааллыг тогтоосноороо өнгө заасан нэрийн орчин үеийн судалгааны эх үндсийг тавьсан гэж үздэг. Өнгөний нэрийг дэлхий даяар хэл шинжлэл, сэтгэл судлал, угсаатны зүй, соёл судлал, урлагийн талаас маш өргөн хүрээнд судалж, соёлын нийтлэг болон ялгаатай онцлог асуудлуудыг нээсээр байна.

Монголчуудын хувьд уламжлалт шүтлэг бөөгийн шашинд хар, цагаан өнгөнөөс улбаатай сайн сайхан, муу муухайн төсөөлөл үүсэж хөгжсөн бөгөөд хөх, шар, улаан, ногоон, цагаан хэмээх үндсэн таван өнгийг ахуй амьдралдаа бэлгэдэж ирсэн гэх баримт судалгаануудад байна. Монголын нууц товчооны өнгөний бэлгэдлийг (Цэдэв, 1997), соёл бэлгэдлийн гол судалгааг (Дулам, 2011) хийсэн бол хэл шинжлэлийн талаас (Рамстедт, 1935), (Базаррагчаа М. , 1997), (Базаррагчаа & Бямбаханд, 2015) нар, сэтгэл хэл шинжлэл, танин мэдэх хэл шинжлэлийн талаас (Уранчимэг, 2004), (Нандин-Эрдэнэ & Нансалмаа, 2015), (Авирмэд, 2022), (Сарангэрэл & Пүрэвсүрэн, 2022) нар судалсан байна.

Дээрх судалгаануудыг нэгтгэн үзвэл, ардын аман зохиол, сурвалж бичигт тулгуурлан өнгө түүгээр илрэх соёл бэлгэдлийг нарийвчлан судалсан бол хэл шинжлэлийн талаас утга судлал, учир зүйн талаас “хар” хэмээх үгийн салаа утгын судалгааг (Базаррагчаа & Бямбаханд, 2015) нэлээн дэлгэрэнгүй авч үзсэн бол бусад судалгаануудад өнгөний нэрийг нэг зохиолын хүрээнд, эсвэл цөөн хэдэн баримтын хүрээнд авч үзэх, мөн сэтгэл хэл шинжлэлийн асуулгын аргаар орчин үеийн хэрэглээг тодорхойлох, монгол хэлний өнгөний нэрийн хэрэглээг англи, франц зэрэг өрнийн хэлтэй харьцуулах зэрэг судалгаанууд хийсэн байна. Тиймээс тодорхой нэгжийн утга хэрэглээний онцлогийг хэрэглэгдэх хам хүрээнд тодорхойлох утга, утга соёлын судалгаа дутмаг байна гэж үзэж болно. Тухайлбал, монгол хүн өнгөнөөс юуг мэдэрч, яаж төсөөлдөг юм бэ? Энэ төсөөллөө илэрхийлэхдээ ямар үгийн сан ашиглаж, ямар утгын хүрээнд хэрэглэж байна вэ? гэдгийг тодруулж, хэлний хэрэглээний утга, хэлний утгад шингэсэн соёл уламжлалын ил далд бүх хэсгийг тодорхой нэг нэгжийн хүрээнд тайлбарласан утга, соёлын судалгаа чухал байна гэж үзлээ.

Өнгөний нэр нь тухайн үндэстний соёл бэлгэдлийн нэг томоохон хэсэг бөгөөд тухайн өнгийг хүртэх таних нийт хүн төрөлхтний нийтлэг мэдрэмжтэй ч холбогддог. Тиймээс монгол хэлний “бор” хэмээх өнгөний нэр түүгээр илрэх шууд ба шууд бус утга хэрэглээг хэлний баримтад тулгуурлан монголчуудын өнгөөр илрэх соёл, сэтгэлгээний онцлогийг тодруулах судалгаа хийхээр тус сэдвийн сонгон авлаа.

Хэлний нэгжүүдийн утгыг судлах замаар хүн төрөлхтөн ертөнцийн юмс үзэгдлийг хэрхэн ойлгож байгааг мэдэх боломжтой. Энэ нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, соёл сэтгэлгээ, шашин, гүн ухаан, зан үйл, гоо зүй, мэдлэг төсөөлөл гээд олон зүйлийг таних боломжийг олгодог. Орчин үед хэлийг хэрэглээний хам орчинд судлах явдал улам гүнзгийрч, хүний тархи, сэтгэн бодох үйл ажиллагаа, соёлын орчин, хэлний хэрэглээ, ахуйтай холбон үзэх болсноор үгийн сангийн нэгжүүдийн утгад шингэсэн хэлний бус соёлын утга хэрэглээг судлан тогтоохыг эрмэлзэх болжээ. Тиймээс ч судлаачид үгийн утгыг хэл, танин мэдэхүй, соёл хэрэглээ хоорондын уулзварт тайлбарлах болсон. Хэл бол хүмүүсийн бүхий л орчин дахь ертөнцийн талаарх ойлголтыг тусгадаг (Чейнки, 2004), үг бол танин мэдэхүйн сүлжээнд нэвтрэх боломжийг олгодог (Лангаскер, 1987) хэмээн үзсэн

бол танихуйн хэл шинжлэлийн төлөөлөгчид танихуйн зүйрлэл бол үгийн сангийн нэгж гэхээсээ илүү цэвэр танин мэдэхүйн үзэгдэл (Гирардс, 2009) гэж тайлбарласан байдаг. Бид үгийн утгын өөрчлөлт, соёл хэрэглээний талын тайлбарлахдаа (Базаррагчаа М. , 1997), (Бланк, 1999), (Вааг, 1908), (Нансалмаа, 2015) хүн төрөлхтний бодож сэтгэж буй ухагдахууны тогтолцоо өөрөө зүйрлэлийн шинжтэй байдаг гэж үзсэн (Лакофф & Жонсон, 2003), (Лакофф Ж. , 2006) нарын танихуйн зүйрлэлийн онол арга зүйг үндэс болгов.

Нэг талаас хэлний нэгжүүдийн утгын гүн бүтцийг тайлахад үгийн утгын өөрчлөлт, өргөсөл, утгын хүрээг¹ орчин үеийн шинжлэх ухаануудын уулзварт шинэлэг арга зүйд тулгуурлан тогтоох, нөгөө талаас хэлний утга, утгын өөрчлөлтүүдийг нарийвчлах судалгаа чухал байгаа энэ үед монгол хэлний уран зохиолын 7,880,161 үгтэй цахим санд тулгуурлан тухайн үгийн утга, утгын өөрчлөлт өргөслийг судлахдаа хам сэдвийн шугаман харьцаанд хамт хэрэглэгдэж буй нийлмэл нэгжийн давталтаас үгийн утгын хүрээг тодорхойлж буйгаараа шинэлэг юм.

Үгийн утгын хэрэглээний нарийн ялгааг илтгэж байгаа хам сэдвийн доторх үг хэллэг нь тухайн ард түмний аж төрөх хэв маяг, ертөнцийг үзэх үзлийн төсөөлөл, үнэт зүйлийн баримжаа, үнэлэмж, ёс заншил гэх мэт соёл уламжлалын бүхий л агуулгыг хадгалж байдаг учраас хам хүрээний орчин дахь үг хэллэгээс үгийн утгын хүрээг тодорхойлох боломжтой. Мөн тухайн үндэстний өнгөний нэрээс улбаалсан утга хэрэглээ маш олон соёлын утгыг тээж байдаг. Тиймээс монгол хэлний “бор” гэх өнгөний нэрээр илрэх утгын өөрчлөлт, өргөслийг соёл, угсаатны зүйн үүднээс тайлбарлаж, утгын хүрээг тодорхойлох ба олон хэлний утгын хүрээтэй харьцуулан ижил төстэй ба ялгаатай талыг тогтоох зорилготой.

СУДЛАГДСАН БАЙДАЛ: Өнгөний нэрийн айн судалгааг хүн судлаач Брент Бэрлин, хэл судлаач Пол Кэй нар (Берлин & Кау, 1969) “Үндсэн өнгөний нэр, тэдний нийтлэг шинж ба хувьсал” бүтээлээрээ хэлний үндсэн өнгөний нэрийн хувьсал, нийтлэг шинжийг харьцуулж, дэс дарааллыг тогтоосноороо өнгө заасан нэрийн орчин үеийн судалгааны эх үндсийг тавьснаас хойш хэлнүүдийн өнгөний нэр томъёог судлах, харьцуулах судалгаа нэлээд хөгжсөн. Тухайлбал, өнгөний нэрийн онтологийн судалгааг (Луйса & Хардин, 1997) эхлүүлж Брент Бэрлин, Пол Кэй нарын загварыг шинэчилж шинэ арга зүйгээр судалсан байна.

Хүн төрөлхтний өдөр, шөнө ээлжлэх явцад гэрэл гэгээ, харанхуй сүүдрийг мэдрэх мэдрэмжтэй холбоотой хар цагааныг үзэх уламжлал сэтгэлгээнээс үүдэлтэй монголчуудын дэлхий ертөнц, амьдралын аливаа зүйлийг өнгөөр ялган ойлгох сэтгэлгээ өөрийн өвөрмөц өнгө аястай хөгжиж ирсэн. Тухайлбал, монголчууд аливаа зүйлийн өнгө, зүсийг ялгахдаа *цагаан, бүгээн, хар, бараан, хөх, улаан, шар, шарга, хүрэн, бор, буурал, саарал, алаг, эрэн, хонгор, цэнхэр, ухаа, гялгар, гялаан, ногоон, цэгээн, халтар, хээр, халуун, цоохор, ягаан, алаг, борлог, харлаг, загал...* гэх мэт олон өнгө зүсний нэрийг хэрэглэж ирсэн байна. Монгол хэлний бэлгэдлийн судалгаа 1980 аад оноос эхэлсэн. МНТ-ны өнгөний нэрийн бэлгэдлийн судалгаа хийсэн (Цэдэв, 1997) бүтээлдээ хар, цагаан хоёр өнгө арга билгийн хослол бөгөөд ‘эцэг эх’ өнгө гэж үздэг хэмээн үзээд монголчуудын хувьд хөх, цагаан, хар өнгө энгийн болоод төрт ёсны бүхий л үйлд хэрэглэдэг бэлгэдэлт өнгө юм гэжээ.

Монголчуудын уламжлалт байгалийн шүтлэг, гүн ухааны үүднээс бол өнгөний бэлгэдлийн хамгийн анхдагч эсрэгцэл нь гэгээ харанхуй, гэрэл сүүдрээс эш үндэстэй хар цагаан хоёр өнгө болно гэж (Дулам, 2011) хэмээн дүгнэсэн бол (Нандин- Эрдэнэ & Нансалмаа, 2015) сэтгэц хэл шинжлэлийн үүднээс монгол хэлний өнгөний нэрийг судлаад Берлин Кеу нарын судалгааны 11 үндсэн өнгө, түүний дараалал монгол хэлний өнгөний нэртэй тохирохгүй байна (Berlin and Kay’s (1969)’s study 11 basic colors in English do not match with Mongolian color terms) гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Харин (Авирмэд, 2022) монгол хэлний өнгө заасан нэрийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс судалсан докторын зэрэг горилсон бүтээлдээ монгол хэлний хар цагаан өнгө олон төрлийн хийсвэр ойлголт илэрхийлж ирсэн хэмээн дүгнэсэн байна.

Монгол хэлний утга судлалд холбогдох талаас монголчууд аливаа зүйлийн өнгө зүсийг хэрхэн оноож хэрэглэх талаар (Базаррагчаа М. , 1997) бичсэн өгүүлэлдээ өнгөний нэрийн гарлыг тайлбарлаж, өнгө зүс заасан үгс тухайн ард түмний ахуй заншил, сэтгэхүй сэтгэгдэлтэй нарийн холбоотой гэж үзээд, үүсмэл утга, бүтцийн утга, бэлгэдлийн утга, сэтгэгдлийн утга хэмээн ангилан үзсэн байдаг.

Судалгааны хязгаарлагдмал тал: Тус өгүүлэл нь “бор” гэх өнгөний нэрийн хам сэдэвт хамт хэрэглэгдэж буй үг хэллэгт тулгуурлан утгын сүлжээг үүсгэж, утга, соёл сэтгэлгээний онцлогийг тодорхойлж байгаа тул ижил үг болон ойролцоо үгийн түвшинд судлахгүй, өнгөний нэрийг нэр томъёоны үүднээс авч үзэхгүй, нөгөө талаас цахим санд тулгуурласан баримтад түшиглэж байгаа тул цөөн хэдэн нэгжийн танихуйн зүйрлэлийн онцлогийг жишээ болгон тайлбарлана. Мөн түүнчлэн зөвхөн уран зохиолын материал дээр тулгуурлаж байгаа тул бусад найруулгад хэрэглэгдэх утга хэрэглээ орхигдсон байж болно. “Semantic map CLICS” дата санг хийсэн арга зүйн дагуу монгол хэлний зөвхөн “бор” гэх нэгжээр илрэх утгын сүлжээг үүсгэн өөрийн судалгаандаа ашигласан.

Эндээс дараах судалгааны асуулт гарч байна.

- “Бор” гэх өнгөний нэрийн утга салаалан өөрчлөгдөхдөө ямар аргаар өөрчлөгдөв? Утга өөрчлөгдөхөд соёл хэрэглээний нөлөө байна уу?
- Эдгээр өнгөний нэр ямар ямар утгын хүрээнд хэрэглэгдэж байна вэ? Энэ утгын хүрээ нь дэлхийн бусад олон хэлний энэ ойлголтоор илрэх утгын хүрээтэй ижил ба ялгаатай тал нь юу вэ?

АРГА ЗҮЙ

1. Утгын өөрчлөлтийг тайлбарлахдаа (Бланк, 1999) үгийн утга шилжих арга, (Вааг, 1908) зүйрлэл үүсэх аргууд болон (Лакофф & Жонсон, 2003) танин мэдэхүйн онол арга зүйн ашиглан “бор” гэх өнгөний нэрээс салаалсан утгын хүрээнээс улбаатай утгалбарын хувилбаруудыг тогтоох, хэрхэн утга өргөссөнийг тайлбарлах, хэлц нэгжийн танихуйн утгыг танин мэдэх зүйрлэлийн онолын үүднээс тайлбарлав.
2. Монгол хэлний уран зохиолын цахим санд (Пүрэвсүрэн, Мөнхдэлгэр, & Насан- Урт, 2015) тулгуурлан “бор” гэх өнгөний нэртэй хам сэдвийн шугаман харьцаанд тохиолдож буй үгсийн түүврийг AntConc 4.0.5 үгийн хайлт хийх, үгийн давтамж дараалал гаргадаг программаар гаргаж, нийлэмж нэгжийн хүснэгт үүсгэн, утгын хүрээг тодорхойлж, CLICS /Database of Cross-Linguistic Colexifications/ дата баазын үр дүнтэй харьцуулав. Эндээс олон хэлнүүдийн утгын хүрээний ижил ба ялгаатай тал харагдана.
3. Цахим сангийн үр дүнгээс монгол хэлний өнгөний нэртэй хамт хэрэглэгдэх нийлмэл нэгжийн хамгийн их давтамж, нийцлийг тодорхойлж, тухайн нэгжийн илэрхийлж буй утгыг бус түүний цаана өгүүлэгдэж буй утгын хүрээг гаргахад чиглэж буй тул хэлний дотоод, гадаад тал, тэрчлэн хэлний бус соёлын хүчин зүйл /бүрдүүлбэр/ чухал юм. Мөн түүнчлэн үгийн утгын тайлбарлах арга зүйд тулгуурлан ажиглах, ангилах, анализ хийх, тайлбарлах, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэв.

ҮР ДҮН

Монгол хэлний өнгөний нэрийн хэрэглээг уран зохиолын санд тулгуурлан судлахад хамгийн түгээмэл хэрэглээтэй, соёл бэлгэдлийн үүднээс эсрэгцсэн олон утгыг үзүүлдэг нэгж нь “хар”, “цагаан” өнгөний нэр байв. Энэ нь дэлхийн олон хэлний түгээмэл үзэгдэл бөгөөд өнгө судлалын талаасаа нэг нь гэрлийг шингээж, нөгөө нь тусгадаг эсрэгцсэн шинж нь олон хэлний үнэлэмж, сэтгэлгээнд тусгалаа олсон байна.

Хүснэгт 1. Өнгөний нэрээр илрэх хамгийн түгээмэл хэрэглэгдэх нийлэмж үгийн давтамж

№	Өнгөний нэр	Давтамж	Нийлэмж үг	Давтамж
1.	цагаан	10491	цагаан гэр, өргөө	460
2.	хар	11617	хар хүн	426
3.	хөх	3857	хөх тэнгэр	522
4.	улаан	5991	улаан туг	187
5.	ногоон	1863	ногоон дарь эх	129
6.	шар	4459	шар цоохор	148
7.	хүрэн	1958	хүрэн улаан	64
8.	ягаан	390	ягаан цэцэг	28
9.	бор	2827	бор морь	210
10.	саарал	709	саарал морь	71
11.	бүгээн	47	бүгээн адуу	9
12.	бараан	586	бараан юм	31
13.	алаг	1924	алаг нүд	327
14.	эрээн	976	эрээн мяраан	63

Монгол хэлний түгээмэл хэрэглээтэй өнгөний нэр болон өнгөний нэрээр илрэх нийлэмжийн давтамжийг 108 ботийн үгсийн санд тулгуурлан (AntConc 4.0.5 программын cluster tools – ээр анализ хийв) харьцуулахад (Хүснэгт 1.) *цагаан гэр, хөх тэнгэр, хар хүн* гэх нийлэмжүүд хамгийн олон тохиолдож байна. “*Цагаан гэр, хөх тэнгэр*” гэх нийлэмж нь монголчуудын соёл бэлгэдлийн уламжлалыг илтгэж байгаа бол “*хар хүн*” гэх нийлэмж нь “хар” гэх өнгөний нэрээс үүдсэн утгын өөрчлөлт их байдгийг илэрхийлж байна. Харин *улаан туг, ногоон дарь эх* нийлэмжээс улс төр, нийгэм, шашны үзэгдэл, *бор морь, саарал адуу, бүгээн адуу* зэргээс малчин нүүдэлчдийн ахуй, *шар цоохор, хүрэн улаан, ягаан цэцэг, бараан юм, эрээн мяраан, алаг нүд* зэргээс юмсын өнгийг ялгах соёл сэтгэлгээний онцлог харагдаж байна. Тиймээс үгийн утгын соёлын бүрдүүлбэрийнⁱⁱ нэг хэсгийг тайлбарлах үүднээс нэгж тус бүрийн утгыг соёл, угсаатны зүйн талаас авч үзэх нь олон талын ач холбогдолтой.

1.“БОР” ӨНГӨНИЙ НЭРИЙН УТГА, УТГЫН ӨӨРЧЛӨЛТ, ӨРГӨСӨЛ

Судлаач С.Дулам (Дулам, 2011) “...Монгол домог зүйд “дээр”, “доор” хоёр буюу орон зайн босоо чигийг төлөөлүүлсэн өнгө нь “хөх”, “бор” хоёр болно” “...Бор зүсэм нь өсөн үржихийн бэлгэдэл болдог” (2011:77) хэмээн тэмдэглэсэн нь монголчууд бор өнгийг газрын өнгө хэмээн үзэж өсөн

дэвжихийн бэлгэдэл гэж үздгийг илтгэж байна. Мөн түүнчлэн бор өнгийг газар шороо, таван махбодыг илэрхийлэх бөгөөд тогтвортой, хариуцлагатай байхын бэлгэдэл хэмээн үздэг (Мөнхцэцэг & Орхон, 2021) бол бат бөх, итгэл найдвартай болон аливаа зүйлийн бодит байдлын илрэл болдог өнгө, мөн байгалийн шинж чанартай өнгө тул дасан зохицох чадвар сайтай, олны дунд байх сонирхолтой, заримдаа хэтэрхий энгийн байдлыг бий болгодог, анхаарал хайхрамж муутай хүний зан байдлыг илэрхийлдэг. <https://mn.wikipedia.org/wiki> гэж ч үздэг байна.

Монгол хэлний тайлбар толь бичигт (Монгол хэлний их тайлбар толь, 2021) 1.Хөх улаан хоёр хольцолдсон хүрэнгэй ойролцоо өнгө, 2. Малын зүс; цагаан зүсэнд улаан хүрэн, хөх, хар зэрэг өнгө, сор хольцолдсон нь, 3.Хүмүүсийн царай зүсний хүрэн хар өнгө, 4.Харуй бүрий, гэгээ муутай бүдэг байдал, 5.Бяцхан, өхөөрдөм, хөөрхөн, 6.Эгэл, жирийн, 7. [Амьтан], ургамлын нэрт хоршин орж тэдгээрийн өнгийг заана гэж 7 салаа утга тэмдэглэжээ.

Харин бусад толь бичигт **Я.Цэвэл**: “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “бор өнгө” гэдэг нь “хар цагаан хоёрын хольцолдсон өнгө, зүс”, “**Хорин наймт тайлбар толь**”-д: “...Эд юмын өнгийн ялгалд цагаавтар өнгөнд бараавтар өнгө хольцсоныг бор хэмээмүй. Цайвар бор, хар бор хэмээн ялгамой”, **Сэцэнцогт**: “Монгол үгсийн язгуурын толь”-д “бор- ① “хөх улаан хоёрын хольцолдсон хүрэнгэй ойролцоо өнгө зүсэм” ② хар цагаан хоёр хольцолдсон сааралтай ойролцоо зүсэм: бор саарал, бор морь ③ хүрэн хар өнгө, голдуу хүний царай зүсийг заадаг: бор хар царайтай хүн, бор хүү, бор хоол, бор ажил...”, **Ц.Норжин**: “① адууны бараавтар саарал зүсэм: бор морь ② харавтар хүрэн өнгө зүсэм: бор түрүүтэй хонь” ③ царай зүсмийн нар салхинд гандсан өнгө: бор хүүхэн ④ юмны өл буурал өнгө...” хэмээн тэмдэглэжээ.

Монгол хэлний “бор” гэх үглэвэр 108 ботийн үгийн санд 3001 удаа тохиолдож байгаагаас тус үгтэй хамт нийлэмж үүсгэж утга илэрхийлж байгаа үгсийн давтамжийг (AntConc 4.0.5 программын cluster tools) анализ хийсэн үр дүнг (Хүснэгт 2) -т үзүүлэв. Үүнээс энэ өнгийг үзэх монголчуудын үнэлэмж, сэтгэлгээ хэлний баримтад хэрхэн туссаныг, тус өнгөний нэрээс улбаалсан утгын өөрчлөлт, утгын хүрээг тодруулах үүднээс дараах харьцуулалтуудыг хийв.

Хүснэгт 2. “Бор” өнгөний нэртэй хамт хамгийн их тохиолдож буй нийлэмжийн давтамж

Нийлэмж үг	Давтамж
Бор морь	210
Бор гэр	74
Бор царай	74
Бор харцага	55
Бор хүү	53
Бор залуу	49
Бор шувуу	44
Бор нүд	42
Бор хүүхэн	42

Хэлний баримтад “бор” гэх өнгөний нэрээс *бор гэр, бор хүүхэн, бор хүү, бор амьдрал, бор тал, бор толгод* гэх нийлмэл нэгж элбэг тохиолдож байгаа нь монголчуудын эгэл энгийн, төв үзлийг баримталдаг үзэл сэтгэлгээний онцлог туссан гэж үзэж болно.

Мөн түүнчлэн “бор” гэх өнгөний нэрээс утга салаалахдаа их төлөв тухайн өнгийг үзэх ард түмний сэтгэлгээ, хэлний бус соёлын хандлага чухал нөлөөлсөн байгаа нь хэлний баримтаас тодорхой байна. Тухайлбал, “бор хоол” гэх нийлэмж нь мах орсон хоол, “бор хоног” гэх нийлэмж нь уйтгартай

удаан гэх, “бор овоохой” гэх нийлэмж нь ядуу зүдүү гэх утгын ялгамжыг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, хам сэдэвт ялгаатай өөр утгыг илэрхийлэхдээ тухайн өнгийг үзэх сэтгэлгээний онцлогтой холбоотой байна. Үгийг проф Б.Пүрэв-Очир “бор гэх чимэг тодотголтой үг хэллэг, нийлэмжүүд ... энгүүн борог амьдралтай малчны хүүхдүүд бид ийм үгтэй илүү ойр байх нийгэм соёлын үндэстэй..” (Пүрэв-Очир, 2013) тэмдэглэсэн байна. Энэ нь (Бланк, 1999) -ын утга өөрчлөгдөх 11 аргын нэг болох зан заншил ёс зүйн улбаатай утга өргөсөж, өөрчлөгдсөн байна гэж үзэж болно. Жишээ нь:

- *Манайх чинь өнөөдөр юугаа идэж, ямар юмаараа **хоногийн бор хоол** залгах вэ? гэсэнд Мядагмаа, -Та надад мөнгө өг! гэв.* (Д.Намдаг. Хярааны хонхорт)
- *Үдэш нь хоёулаа хамжин байж жаахан **бор хоол** хийж идээд унтахаар хэвтэцгээв.* (С.Лочин. Сэтгэлийн өнгө)
- *Дэлгэр хэмээх тэр номхон **бор хүү** намайг санамсаргүй эзэмдэж, надад бас уйтгар харуусал үүрд үлдээсэн юм.* (С.Пүрэв. Гэгээн хайрын мөргөл)
- *Үдшийн **бор гэгээ татаж, түрүүчийн од цэцэглэхийн алдад Шарав гуай бид хоёр ор, дэрээ засаж хэвтэхээр завдсан хэдий ч хэн маань ч яаран хажуулсангүй.*** (Б.Догмид. Нэхэл хатуу орчлон)
- *Хот хүрээ газар гэдэг чинь хөл үймээн ихтэй, төөрч яваад төрөл арилжихад ч амархан, түших хүнгүй бол **бор гэдэс** тэжээнэ гэдэг хэцүү.* (С.Лочин. Сэтгэлийн өнгө)

Энэ бүгдээс улбаалан тус судалгаанд хам бичвэрийн нийлэмжийн утгын орчинд тухайн үглэврийн утгын өргөсөл хэрхэн явагдаж байгааг судалж үзэхэд дараах утгалбаруудаар хүрээгээ тэлж, (хүснэгт 3) таван утгалбар илэрхийлж, утга өргөсөн тэлж байгааг ажиглахад II-V дахь утгалбар танихуйн зүйрлэлийнⁱⁱⁱ хүрээнд утга шилжиж, соёлын сэтгэлгээний онцлогийн үүднээс бүтсэн гэж үзэж болно.

Хүснэгт 3. “Бор” өнгөний нэрээс салаалсан утгалбар

I	II	III	IV	V	VI
✓ бор гэр	✓ бор гэр	✓ бор гэр	✓ бор хүү	✓ бор сүүдэр	✓ бор гэгээ
✓ бор царай	✓ бор хүү	✓ бор ажил	✓ бор охин	✓ бор тал	✓ бор түүш
✓ бор жаал	✓ бор амьдрал	✓ бор өдөр	✓ бор тоором	✓ бор толгод	✓ бор хараа
✓ бор харцага	✓ бор амь	✓ бор бааз	✓ бор хацар, гар		✓
✓ бор тал	✓ бор овоохой	✓ бор тал	✓ бор гэдэс		
✓ бор нүд		✓ бор ааш	✓ бор гүзээ		
✓ бор авдар		✓ бор ухаан	✓ бор		
✓ бор гурил			ходооднууд		
			✓.. бор авдар		

Үүнийг задлан тайлбарлавал, I – өнгөний нэрийн цөм утгаас шууд үүссэн, II – ядуу, дорой, III – эгэл энгийн, IV – бяцхан өхөөрдөм, энхрий дотно, V- дулаан тайван, VI – харанхуй, бүрэнхий гэх утгалбаруудаар салаалж утга өөрчлөгджээ. Үгийн сангийн утгыг бүрдүүлж байгаа утганцраас гадна тухайн үгэнд тухайн үндэстний соёлын утга шингэж үгийн олон утгыг үүсгэж, утгын өргөсөл үүсэх үндэс болдог. Тухайлбал, “бор” гэх үглэврийн эгэл, энгийн гэх утганцраас улбаалан “бор зам”, “бор заяа” гэх мэт хам бичвэрийн утга үүсжээ.

Судалгааны баримтаас үзэхэд “бор” өнгөний нэрээр газар орон, ургамал амьтан, хүн, эд агуурстай холбогдох зүйлийг нэрлэх нь түгээмэл байгаа ч хүний хараа зүй, цаашилбал сэтгэл зүйд нөлөөлөх мэдрэмж, соёл бэлгэдлээс үүдэлтэй хийсвэр утга их тохиолдож байгаа нь нэг талаас тухайн үгийн гарал зүйтэй, нөгөө талаас танин мэдэх сэтгэлгээний онцлогтой холбогдож танихуйн зүйрлэлийн аргаар бүтсэн байна. Тухайлбал, *бор амьдрал, бор хоол, бор хоормог, бор хацар, бор гэдэс, бор юм,*

бор цаас гэх мэт нийлмэл нэгж үүсгэж, хэлний хэрэглээнд *ээжийн бор охин, минь бор хүү*, ээжийн бор аялга, *эмээгийн бор авдар, нутгийн бор тал, намхан бор толгод*, болзоотын бор толгой, нисдэг бор морь, боож үхэх бор шидэмс, *Дулмаа чавганцын бор овоохой, бор ходоодоо дүүргэх, бор гэдсээ тэжээх, нутгийн бор бүсгүй, адуучин бор залуу* гэх мэт дүрслэлүүд уран зохиол, аман зохиолд хэвшжээ.


Монгол хэлэнд “бор” гэх өнгөний нэртэй холбоотой утга үүсэж хэрэглэгдэх, өргөсөх үзэгдэл нь

- ❖ *Газар шорооны өнгө тул уул, толгод, ухаа, гүвээ, тал, тойром гэх мэт газрын өнгөн хэсэгт байх хөрст хэсгийн өнгийг заах,*
- ❖ *Хүн төрөлхтний арьсны нэг өнгө тул хүний царай зүсийг заах,*
- ❖ *Энгийн жирийн энгийн гэх байдлыг,*
- ❖ *Ядуу зүдүү, гачлантай байдлыг,*
- ❖ *Дулаан тайван, тогтвортой байдлыг*
- ❖ *Уйтгар гунигтай байдлыг илэрхийлж бүтсэн нь олон соёлын нийтлэг гэж үзэж болохоор байгаа нь дээрх мэдээллүүдээс тодорхой байна.*

Харин бяцхан, өхөөрдөм, энхрий дотно, харуй бүрий, бүрэнхий байдлыг илэрхийлж бүтсэн нийлмэл нэгжүүдийн утга соёлын холбогдол нь монголчуудын онцлог гэж үзэж болохоор байна. Түүнчлэн “бор” үглэвэр оролцож бүтсэн хэлц нэгжүүд монголчуудын соёл бэлгэдлийн утгыг хадгалж бүтжээ. Өнгөний нэрээс утга салаалан хэрэглэгдэх үзэгдэл нь тухайн өнгөнөөс хүнд төрөх сэтгэл зүйн шинжтэй нягт холбоотой байгаа нь дээрх жишээнээс харагдаж байна. Монгол хэлэнд хэвшсэн бор өнгөний мэдрэмж нь нэг ижилхэн өнгө бус байгаа нь мал амьтны зүс, ахуй соёлтой холбоотой үг хэллэгээс харагдаж байна.

Дээрх үр дүнгээс монгол хэлний “бор” өнгөний нэрийн хэрэглээнээс утгын хүрээг гаргаж үзэхэд дараах байдалтай байна. Утгын хүрээг нэгтгэснийг /бүдүүвч 1/-д үзүүлээ.

Бүдүүвч 1. Монгол хэлний “бор” өнгөний нэрээр илрэх утгын хүрээ



Ийнхүү монгол хэлний “бор” өнгөний нэрийн хэрэглээ, утгын өөрчлөлтийг цахим санд тулгуурлан судалж үзэхэд монголчуудын аж ахуйтай холбогдох юм, эд, мал сүргийн зүс, мөн түүнчлэн газрын өнгө, эгэл энгийн, энхрий дотно, бяцхан өхөөрдөм, тогтвортой, найдвартай, урт удаан гэх мэт утгын хүрээг илэрхийлж бүтэх онцлогтой. Мөн түүнчлэн Монгол хэлний “бор” гэх өнгөний нэрээс улбаатай утгын хүрээг дэлхийн 3156 хэлийг багтаасан утгын хүрээтэй (semantic map)^{iv} харьцуулж үзэхэд адил үр дүн байхгүй бөгөөд монгол хэлний өнгөний нэрийн хувьд дэлхийн олон хэлнээс бор өнгөний нэрийн хэрэглээгээр ялгаатай байна. Үүнийг англи монгол хэлний өнгөний нэрийн харьцуулсан судалгаандаа судлаач О.Нандин-Эрдэнэ тэмдэглэсэн байдаг.

“Бор” өнгөний нэр (үглэвэр) орж бүтсэн нийлмэл нэгжийн судалгааны үр дүнг нэгтгэж үзэхэд бор өнгөөр илэрхийлэх танихуйн эх сурвалж нь “энгүүн, энгийн”, “төв, тогтвортой” гэх монголчуудын сэтгэлгээнд хэвшиж тогтсон домайнтай холбогдож хэлц нэгжүүд үүсжээ. Зарим хэлц нэгжийн бүтсэн танихуйн зүйрлэлийг тайлбарлав.

Хүснэгт 4. Зарим хэлц нэгжийн утгын танихуйн зүйрлэлийн тайлбар

Хэлц	Үүсэл санаа	Утга
Бор амьдрал	<p>- Бор өнгийг газар шороо, таван махбодыг илэрхийлдэг гэж үздэгтэй,</p> <p>- Танин мэдэхүйн үүднээс босоо тэнхлэгийн хувьд газар бидний хөл дор байдагтай, бидний сэтгэлгээний онцлогт дээд тал эерэг санй сайхантай холбон үздэгтэй холбогдоно.</p> <p>Дундад зууны үед дэлхийн хүн төрөлхтөн бор өнгийг ядуу зүдүүгийн бэлгэдэл болгодог байсан сэтгэлгээний нийтлэгтэй ч холбогдож байна.</p>	Ядуу зүдүү, хөөрхийлөлтэй амьдралыг илэрхийлсэн утга

Бор тураг	<i>Монголчуудын хувьд махыг төлөөлүүлэн нэрлэдэгтэй холбогдоно. Дан мах, булчин</i>	Үнэгэн чих, урт хошуу, нарийн хөл бүхий толгой томтой хурдан морины шинж
Бор зүрхээрээ зүтгэх	Зүрхээр хүнийг төлөөлүүлсэн.	- Дан өөрийн биеэр зүтгэх, амьдрах, бие дааж хөдөлмөрлөх
Хэдэн бор юм	<i>Хөлс хүчээ зарцуулж олсон мөнгийг төлөөлүүлсэн.</i> <i>Саяхан энэхүү ботийн шагнал болох цөөн хэдэн бор юм аваад сүрхий баярлаж, -Хэдүүлээ наргина аа гэсээр “Цагаан архи” басхүү даруулга болгож чихэр жимс, авчирч, хүүхэд шиг баярлаж суусныг би санаж байна. /Д.Төрбат.Чандманийн түлхүүр/</i>	Ажил хийж олсон мөнгө төгрөг, цалин
Бор хоол		Дан махан буюу мах оролцсон хоол

ДҮГНЭЛТ

Монгол хэлний 7,880,161 үгийн сантай баримтад тулгуурлан судалсан “бор” гэх өнгөний нэрээс улбаатай нийлмэл нэгжийн утгын олон хувилбар үүсэх явц нь үгийн сангийн утгаас гадна хэлний соёл хэрэглээ, хэлний үнэлэмж, бэлгэдэлтэй холбогдож, утгалбарын хувилбар буюу салаа утгууд нь нийлмэл нэгжээр илрэхдээ цөм танихуйн зүйрлэлийн шинжтэй, соёл сэтгэлгээний онцлогийг тээж бүтжээ. “Бор” өнгөний нэрээс улбаатай утгын өөрчлөлтийг утганцарын шинжид тулгуурлан ангилан үзэхэд 6 утгалбар буюу салаа утгыг үүсгэж байна. Дэлхийн 3156 хэлийг багтаасан утгын хүрээтэй (semantic map) харьцуулж үзэхэд бороор илрэх утгын дэд хүрээ үүссэн хэл байхгүй байгаа нь монголчуудын хувьд “бор” өнгөөр илрэх утгын хүрээ нь бусад хэл соёлт ард түмнээс ялгаатай байна.

“Бор” өнгөний нэрээс улбаатай утгын өөрчлөлт 6 утгалбар үүссэн бөгөөд “*өнгө, ядуу дорой, эгэл энгийн,энхрий дотно, дулаан тайван, харанхуй бүрэнхий*” гэсэн ялгаатай утгын хүрээг үүсгэж, утгын өргөсөл нь бор өнгөний хүний сэтгэл зүйд нөлөөлөх нөлөөлөл болон хүн төрөлхтний орон зайн босоо чигийн төлөөлүүлсэн “хөх”, “бор” өнгөний бэлгэдэлтэй холбоотой газар хөрсний өнгө, мөн хүний царайны өнгөнөөс улбаатай нийлмэл нэгж үүсэх суурь болж, утга өргөжин тэлжээ.

Энэхүү өгүүлэл нь нэг талаас монгол хэлний үгийн сангийн нэгжийн утга, соёлын өвөрмөц хэрэглээний талын тодруулан, үгийн утга түүгээр илрэх үнэлэмж, соёлын асуудлыг хөндсөнөөрөө үгийн сангийн утга судлал, үгийн утгын соёл танихуйн асуудал, угсаатны зүйн судалгаанд ач холбогдолтой. Нөгөө талаас тухайн ард түмний түүх, ёс заншил, амьдралын тогтсон хэв маяг, сэтгэлгээний онцлогийг хэлээр дамжуулан сурдаг тул монгол хэл сурах, заах асуудалд тодорхой хувь нэмэр оруулахаас гадна соёлыг хэлээр дамжуулан таниулах, хамгаалахад чухал ач холбогдолтой.

Эцэст тэмдэглэхэд олон хэлний хоорондын машин орчуулга, цахим технологи хөгжиж буй энэ цаг үед хэлний нэгжүүдийн утгыг хэл, соёл, угсаатны зүйн талаас тайлбарласан энэ төрлийн судалгаа нэн чухал гэж үзлээ.

An exploration of semantic extensions in Mongolian color terms

Sarangereel Ravjir^{ID}

Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

ABSTRACT

This article examines the meanings, transformations, and extensions of nouns denoting the color “brown” in the Mongolian language, with a specific focus on semantic and cognitive approaches. The analysis identifies six distinct semantic categories, or semantemes, derived from the color term “brown”: “color representation, poverty, simplicity, tenderness, warmth, calmness, and darkness.” Notably, the semantic map associated with “brown” in Mongolian differs significantly from that of other linguistic and cultural groups.

The extension of meaning associated with the color “brown” is influenced by its psychological impact on human perception, as well as by its symbolic relationship with “blue” and “brown” in representing vertical spatial orientation in Mongolian culture. This symbolic association serves as a foundation for constructing complex semantic units within the color lexicon, particularly in expressions describing facial color. These semantic extensions go beyond the basic lexical meaning of words, encompassing cultural connotations, values, and symbols embedded in the language. The alternative semantemes or derived meanings, when combined into a complex unit, acquire a metaphorical quality that reflects cognitive processes and embodies cultural thought patterns. The shift in meaning is closely linked to the development and evolution of vocabulary, shaped by etymology, national symbols, and cultural nuances. This article argues that constructing semantic maps for vocabulary units, and investigating semantic shifts and extensions based on these units, are essential for advancing research in semantics and comparative linguistic studies across languages.

Keywords: *Bor (brown), color name, semantic change, extension, semantic map (range), metaphor*

НОМ ЗҮЙ

Berlin, B., & Kay, P. (1969). *Basic Color Terms Their Universality and Evolution*. Los Angeles: University of California Press Berkeley.
<https://books.google.mn/books?id=sGDxruwl9OkC&printsec=frontcover#v=onepage&q&f=false>

- Blank.A. (1999). Polysemy in the Lexicon. *Semantic change - Semantic extension* (pp. 11-29).
https://www.academia.edu/67036180/Polysemy_in_the_Lexicon
- Cienki, A. (2004). *Frames, idealized cognitive models, and domains*. Oxford: Oxford University press.
<https://doi.org/10.1093/oxfordhb/9780199738632.013.0007>
- Geeraerts. Dirk, (2009) *Theories of Lexical Semantics* (Oxford Academic, 1 Feb. 2010), <https://doi.org/10.1093/acprof:oso/9780198700302.001.0001>
- Hardin, C. L., & Maffi, L. (Eds.). (1997). *Color Categories in Thought and Language*. Cambridge: Cambridge University Press. <https://doi.org/10.1017/CBO9780511519819>
- Lakoff, G. (1993). *The contemporary theory of metaphor*. In A. Ortony (Ed.), *Metaphor and Thought* (pp. 202–251). chapter, Cambridge: Cambridge University Press.
<https://doi.org/10.1017/CBO9781139173865.013>
- Lakoff, George & Johnson, Mark (1980). *Metaphors we live by*. Chicago: University of Chicago Press.
Edited by Mark Johnson.
- Newcomer, P., & Faris, J. (1971). Basic Color Terms. *International Journal of American Linguistics*, 37(4), 270–275. <http://www.jstor.org/stable/1264519>
- Ramstedt, G. J. (1935). *Kalmuckisches wörterbuch*. Helsinki.
https://altaica.ru/LIBRARY/ramstedt/Ramstedt_Kalmykisches_Worterbuch.pdf
- Ronald W. Langacker. (1987). *Foundations of Cognitive Grammar*. ISBN: 9780804764452. Stanford: Stanford University Press. <https://www.sup.org/books/science/foundations-cognitive-grammar>
- Waag, A. (1908). *Development of meaning in our vocabulary, A look into the inner life of words*. Berlin: DOI:10.1093/acprof:oso/9780198700302.001.0001
- Авирмэд, М. (2022). *Монголчуудын үндсэн өнгөний нэрийг танихуйн хэл шинжлэлийн үүднээс судлах нь*. Хөх хот: Өвөр Монгол.
- Базаррагчаа, М. (1997). Монголчууд өмнө зүг чигийг хэрхэн нэрлэдэг вэ? *Монгол Улсын Их Сургуулийн сэтгүүл*, 9 (126), 8-21. Улаанбаатар:
- Базаррагчаа, М., & Бямбаханд, Ч. (2015). *Монгол хэлний "хар" хэмээх үгийн салаа утгын онцлог*. Улаанбаатар:
- Дулам, С. (2011). *Монгол бэлгэдэл зүй, Өнгийн бэлгэдэл зүй, Чиг зүгийн бэлгэдэл зүй* (Vol. II). (S. o. Mongolian Symbolism, Trans.) Улаанбаатар: Бит пресс.
- Монгол хэлний их тайлбар толь*. (2021). <https://mongoltoli.mn/dictionary/detail/122192>
- Мөнхцэцэг, Г., & Орхон, Б. (2021). *Монгол орон судлал*. Улаанбаатар:
- Нандин-Эрдэнэ, О., & Нансалмаа, Н. (2015). *Монгол хэлний өнгөний нэрийн судалгаа*.

Нансалмаа, Н. (2015). *Үгийн сан судлал*. Улаанбаатар:

Пүрэв-Очир, Б. (2013). *Судалбар эсээнүүд*. Улаанбаатар:

Пүрэвсүрэн, Т., Мөнхдэлгэр, Т., & Насан- Урт, С. (2015). МУЗД 108 ботийн цахим сан программ хангамж. Хөх хот:

Сарангэрэл, Р., & Пүрэвсүрэн, Г. (2022). Монгол хэлний үгийн утга, бүтцийг цахим санд суурилан судлах нь. *Мишээл "институт"-ын олон улсын дөрөвдүгээр хурал*. Солонгос.

Уранчимэг, Б. (2004). *Өнгө заасан үг хэллэгийг когнетив хэл шинжлэлийн үүднээс судлах нь*. (С. о. Mongolian, Trans.) Улаанбаатар:

Цэдэв, Д. (1997). *Монголын нууц товчооны бэлгэдэл*. Улаанбаатар:

Note

ⁱ Хам сэдвийн шугаман харьцаанд хамт хэрэглэгдэж байгаа холбоо үг, нийлмэл нэгж нь тухайн утгын хүрээг тодорхойлдог. Тийм учраас судлаач (Tsog-Ochir, 2014) өгүүлэлдээ “үгийн утгын хэрэглээний нарийн ялгааг илтгэж буй хам хүрээллийн доторх үг хэллэг бүрийн цаана ард түмний аж төрөх хэв маяг нь ертөнцийг үзэх үзлийн төсөөлөл, үнэт зүйлийн баримжаа, сэтгэл зүйн шинж байдал, үндэстний өвөрмөц онцлог, ёс заншил, уламжлалын хамт ил ба далд байдлаар оршиж байдаг” гэж тэмдэглэсэн байдаг.

ⁱⁱ Үг бол бодит ертөнцийн юмс үзэгдлийг нэрлэсэн, тэдгээрт оноосон тэмдэг учир түүний утгад “хэлний бус” утгын бүрдүүлбэр байх нь зайлшгүй. Хэл шинжлэлд Оросын эрдэмтэн Н.Г. Комлев үгийн утгын “соёл -түүхийн бүрдүүлбэр”-ийн тухай санааг дэвшүүлж “үгийн дотоод агуулга байгааг хүлээн зөвшөөрөхдөө үг- тэмдэг нь өөрөөсөө өөр ямар нэг зүйлийг илэрхийлдэг гэвэл бид хувь хүний соёлын орчноос хэлний утга хамааралтай гэж үзэж үгийн утгад соёлын бүрдүүлбэр байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй” (Нансалмаа, 2015) гэж тэмдэглэжээ.

ⁱⁱⁱ In a metaphor; there are two domains, which is constituted by the immediate subject matter, and the source domain, in which important metaphorical reasoning takes place and that provides the source concepts used in that reasoning. Metaphorical language has literal meaning in the source domain. (Лакофф & Жонсон, 2003)

^{iv} By sorting the dimensions into domains, I define properties and concepts and show how prototype effects of concepts can be treated with the aid of conceptual spaces. I present an outline of how one can reconstruct most of the taxonomies and other meta-data that are explicitly coded in the current Semantic Web and argue that inference engines on the symbolic level will become largely superfluous. As an example of the semantic power of conceptual spaces, I show how concept combinations can be analyzed in a much richer and more accurate way than in the classical logical approach. (Gärdenfors, 2004)